



ГЭМТ ХЭРЭГ, 2021 оны эхний 2 сарын байдлаар


ᠭᠡᠮᠡᠲᠦ ᠬᠡᠷᠢᠭ



Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг



Бүсээр



↓ ↑ Өмнөх оны мөн үетэй харьцуулахад, хувиар

Гэмт хэргийн улмаас



Хохирсон хүн

3 666



Гэмтсэн хүн

1 252



Нас барсан хүн

173

2/2021

Тархаасан: 2021 оны 3 дугаар сарын 12




Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 2747 (40.7%) -гоор буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэрэг 2021 оны эхний 2 сард 3998 болж, өмнөх оны мөн үеэс 2747 (40.7%)-гоор буурч, харин өмнөх сараас 474 (26.5%)-өөр өссөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх сараас өсөхөд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 268 (32.5%)-аар, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 131 (25.6%)-ээр, залилах гэмт хэрэг 91 (23.9%)-ээр, хулгайлах гэмт хэрэг 87 (35.5%)-гоор өссөн нь голлон нөлөөлжээ.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг 2021 оны эхний 2 сард улсын дунджаар 19 болж, өмнөх оны мөн үеэс 13 (40.6%)-аар буурсан байна.

Зураг 1. Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар



Нийт гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс буурахад өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 2306 (54.7%), хулгайлах гэмт хэрэг 1267 (68.7%), залилах гэмт хэрэг 354 (29.5%), мал хулгайлах гэмт хэрэг 258 (56.8%), хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 281 (19.2%), хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг 126 (53.6%), золгүй явдлаар нас барсан хэрэг 107 (52.5%), хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 106 (39.0%), хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 107 (48.9%)-гоор тус тус буурсан нь голлон нөлөөлжээ. Харин олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 145 (3.3 дахин), хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг 32 (2.0 дахин)-оор тус тус өссөн байна.


Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 279 хэргийн 21 (7.5%) нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл (Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг)-ээр зүйлчлэгдсэн байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 2021 оны эхний 2 сард 21 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2 (8.7%)-оор буурсан байна. Харин гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 2021 оны 2 дугаар сард 14 бүртгэгдсэн нь өмнөх сараас 6 (75.0%)-гаар өссөн байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 2021 оны эхний 2 сард 1750 зөрчил бүртгэгдсэний 1112 (63.5%) зөрчлийг шалган шийдвэрлэсэн байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн нийт зөрчил өмнөх оны мөн үеэс 161 (8.4%)-ээр, шийдвэрлэсэн зөрчил 176 (13.7%)-гаар түс түс буурсан байна.

Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 2021 оны эхний 2 сард 618 болж, өмнөх оны мөн үеэс 192 (45.1%)-оор, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн хэрэг 279 болж, 109 (64.1%)-өөр өсөж, харин эмэгтэй хүн оролцсон хэрэг 370 болж, 170 (31.5%), бүлэглэн үйлдсэн хэрэг 194 болж, 100 (34.0%)-гаар, хүүхэд оролцсон хэрэг 37 болж, 27 (42.2%)-гоор, мансуурсан үедээ үйлдсэн хэрэг 33 болж, 5 (13.2%)-аар түс түс буурсан байна.

Зураг 2. Учирсан хохирол, нөхөн төлүүлсэн хохирол, сараар, тэрбум төгрөгөөр



Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2021 оны эхний 2 сард 31.3 тэрбум төгрөг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 2.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс учирсан хохирол 2.8 (8.1%) тэрбум төгрөгөөр буурч, нөхөн төлүүлсэн хохирол 256.1 (9.7%) сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Гэмт хэргийн улмаас хохирсон, гэмтсэн, нас барсан хүн, насны бүлгээр, хүйсээр, жил бүрийн эхний 2 сарын байдлаар


Үзүүлэлт	Хохирсон хүн		Гэмтсэн хүн		Нас барсан хүн	
	2020 I-II	2021 I-II	2020 I-II	2021 I-II	2020 I-II	2021 I-II
7 хүртэлх	36	25	8	7	21	8
8-17	228	132	58	44	11	7
18-29	1 619	872	468	353	31	27
30-39	2 052	1 207	515	428	48	47
40-49	1 405	836	270	245	77	38
50-59	822	428	161	128	70	29
60-69	289	138	41	37	24	14
70, түүнээс дээш насны	66	28	8	10	9	3
Улсын дүн	6 517	3 666	1 529	1 252	291	173
Эмэгтэй	2 724	1 551	601	507	71	45

Гэмт хэргийн улмаас хохирсон хүн 2021 оны эхний 2 сард 3.7 мянга болж, 157 (4.3%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 1551 (42.3%) нь эмэгтэйчүүд байна.

Гэмт хэргийн улмаас 2021 оны эхний 2 сард 1252 хүн гэмтэж, 173 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеэс гэмтсэн хүн 277 (18.1%)-гоор, нас барсан хүн 118 (40.5%) -аар буурсан байна.

Гэмт хэргийн улмаас 2021 оны эхний 2 сард хохирсон 3666 хүний 25 (0.7%) нь 7 хүртэлх насных, 132 (3.6%) нь 8-17 насных, 872 (23.8%) нь 18-29 насных, 1207 (32.9%) нь 30-39 насных, 836 (22.8%) нь 40-49 насных, 594 (16.2%) нь 50, түүнээс дээш насныхан байна.

Зураг 3. Гэмт хэрэгт холбогдсон яллагдагч, насны бүлгээр, жил бүрийн эхний 2 сарын байдлаар



Гэмт хэрэгт холбогдсон нийт яллагдагчдын тоо 2021 оны эхний 2 сард 1797 болж, өмнөх оны мөн үеэс 63 (3.6%)-аар өссөн байна. Нийт гэмт хэрэгт холбогдсон яллагдагчийн 43 (2.4%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 211 (11.7%) нь эмэгтэйчүүд байна.

Гэмт хэрэгт 2021 оны эхний 2 сард холбогдсон нийт 1797 яллагдагчийн 18 (1.0%) нь 14-15 насных, 25 (1.4%) нь 16-17 насных, 660 (36.7%) нь 18-29 насных, 655 (36.5%) нь 30-39 насных, 286 (15.9%) нь 40-49 насных, 153 (8.5%) нь 50, түүнээс дээш насных байна.

Улсын хэмжээнд 2021 оны эхний 2 сард 12.4 мянган хүн эрүүлжүүлэгдэж, 2.1 мянган хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеэс эрүүлжүүлэгдсэн хүн 5.1 (29.1%) мянгаар, баривчлагдсан хүн 36 (1.7%)-гаар буурсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000-аар үржүүлж тооцно.

Хохирогч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.

Эх үүсвэр: Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл



Ангилал, код: Гэмт хэргийн статистикийн олон улсын ангилал

Мэдээлэл авах линк:

<http://www.nso.mn/>
<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 4 дүгээр сарын 15

*Хүн ам, нийгмийн статистикийн
газрын дарга А.Амарбал
Утас: (976-51)-264805*

*Хүн ам, нийгмийн статистикийн
газрын статистикч Ц.Дулмаа
Утас: (976-51)-263966*

